



МОНГОЛ УЛСЫН
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН
ТУШААЛ

2023 оны 12 сарын 01 өдөр

Дугаар 1/351

Улаанбаатар хот

Аргачлал батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.Хүнд үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах аргачлалыг хавсралтаар баталсугай.


2.Батлагдсан аргачлалын дагуу боловсруулагдсан техник, эдийн засгийн үндэслэлийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Боловсруулах үйлдвэрийн салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлэж байхыг Хүнд үйлдвэрийн бодлогын газар (С.Сүхбат)-т даалгасугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Т.Баасанпүрэв)-т үүрэг болгосугай.

4.Энэ тушаал гарсантай холбогдуулан 2017 онд батлагдсан “Хүнд үйлдвэрийн салбарын техник, эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба хүлээн авах журам” хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Ж.ГАНБААТАР



Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын
2020-ны 12 дугаар сарын 01-ний өдрийн
1/359 дугаар тушаалын хавсралт

ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ БОЛОВСРУУЛАХ АРГАЧЛАЛ

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Энэхүү аргачлал нь хүнд үйлдвэр байгуулах, үйлдвэрлэлийн хүчин чадлыг өргөтгөх, техник, технологийг шинэчлэхэд чиглэгдэх бөгөөд төслийн техник, эдийн засгийн үндэслэлийн үе шат, бүтэц агуулгыг тодорхойлох зорилготой.
- 1.2. Төсөл хэрэгжүүлэгч болон боловсруулагчид үйлдвэрийн урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл, үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл, үйлдвэрийн нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэлийг энэ аргачлалын дагуу хийж гүйцэтгэх ба төсөл хэлэлцүүлэгч нь техник, эдийн засгийн үндэслэлийг хэлэлцэх, хүлээн авахад ашиглана.
- 1.3. Үйлдвэрийн урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл нь техник, эдийн засгийн үндэслэл, нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах үндэслэл болно.

Хоёр. Нэр томьёоны тодорхойлолт

- 2.1. Энэхүү аргачлалд хэрэглэсэн нэр томьёог дараах утгаар ойлгоно. Үүнд:

“Урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл” гэж хүнд үйлдвэрлэлийн төсөл хэрэгжүүлэх хувилбаруудын техник, технологийн боломж түүний харьцуулсан судалгаа, эдийн засгийг тооцсон техникийн баримт бичгийг;

“Үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл” гэж хүнд үйлдвэрлэлийн төсөл хэрэгжүүлэхэд чиглэсэн техник, технологийн сонголт, тооцоо, судалгаа, инженерийн шийдэл, хүрээлэн буй орчинд нэлөөлөх байдал, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, хүний нөөц, удирдлага, зохион байгуулалт, дэд бүтэц, хангамж, нийгэм, эдийн засгийн үр ашиг, зардлын тооцоолол болон холбогдох бусад судалгааны материал, мэдээ, мэдээллийг гарган харуулсан зураг, тооцоо, тайлбар, дүгнэлт хэсгээс бүрдэх техникийн баримт бичгийг;

“Үйлдвэрийн нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэл” гэж хүнд үйлдвэрлэлийн техник, технологийн сонголт, үйл ажиллагаа, үйлдвэрийн барилга, тоног төхөөрөмжийн сууринуулалт, инженерийн шийдэл, хүний нөөц, удирдлага зохион байгуулалт, байгаль орчин, хүрээлэн буй орчинд нэлөөлөх байдал, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, дэд бүтэц, хангамж, нийгэм эдийн засгийн үзүүлэлтүүдийн тооцоолол, шаардагдах хөрөнгө оруулалтын хэмжээ болон холбогдох бусад судалгааны материалыг нарийвчлан харуулсан зураг, тооцоо, тайлбар, дүгнэлт хэсгээс бүрдэх техникийн баримт бичгийг;

“Төсөл хэрэгжүүлэгч” гэж хүнд үйлдвэрийн салбарт шинэ төсөл хэрэгжүүлэгч, энэ чиглэлээр үйлдвэрлэл эрхлэгч, үйлдвэрийг сэргээн засварлах, өргөтгөх, үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнийн тоо хэмжээг нэмэгдүүлэхээр зорин ажиллаж байгаа хуулийн этгээдийг;

“Төсөл боловсруулагч” гэж хүнд үйлдвэрийн салбарт эрдэм шинжилгээ, судалгаа, зураг төсөл хийх тодорхой туршлагатай, салбарын эрдэмтэн, судлаач, мэргэжлийн зөвлөхтэй эрх бүхий хуулийн этгээдийг;

“Төсөл хэлэлцүүлэгч” гэж хүнд үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайдын тушаалаар байгуулагдсан зөвлөлийг;

Гурав. Төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулахад баримтлах зарчим

- 3.1. Техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ) нь төслийг хэрэгжүүлэх эсэх талаар оновчтой шийдвэр гаргахад чиглэгдсэн байх ба үнэн зөв бодитой мэдээ, мэдээлэл, тооцоо судалгаанд үндэслэгдсэн байна.
- 3.2. Техник, эдийн засгийн үндэслэл боловсруулагч хуулийн этгээд нь Хүнд үйлдвэрийн барилга байгууламжийн технологийн зураг төсөл, Уул уурхайн технологийн зураг төсөл, ТЭЗҮ боловсруулах, Тухайн ажлын төрлийн хүрээнд ТЭЗҮ боловсруулах тусгай зөвшөөрөлтэй байна.
- 3.3. Техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах судалгааны баг нь төслийн онцлогоос хамаарч хэдэн ч судлаачийн бүрэлдэхүүнтэй байж болох ч тухайн төсөл хэрэгжих салбарын инженер, техникийн мэргэжилтнүүдтэй байвал зохино.

Дөрөв. Урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэлийн бүтэц, агуулга

4.1. Хүнд үйлдвэрлэлийн төслийн урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл (УТЭЗҮ) дараах бүтэцтэй байна. Үүнд:

4.1.1. Нүүр хуудас - Төслийн нэр, байршил, хүчин чадал, хэрэгжүүлэгч, боловсруулагч хуулийн этгээдийн нэр, огноо

4.1.2. Гарын үсэгний хуудас

- Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн даргын овог нэр, гарын үсэг, тамга, тэмдэг /Танилцсан/
- Төсөл хэрэгжүүлэгч хуулийн этгээдийн удирдлагын овог нэр, гарын үсэг, тамга, тэмдэг /Баталсан/
- Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Боловсруулах үйлдвэрийн салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын овог нэр, гарын үсэг /Хянасан/
- Төслийн зөвлөх инженерийн овог нэр, гарын үсэг, тэмдэг
- Шинжээчийн овог нэр, гарын үсэг /Монгол Улсын зөвлөх болон мэргэшсэн инженер бол тамга, тэмдэг дарна/

- Төсөл боловсруулсан хуулийн этгээдийн удирдлагын овог нэр, гарын үсэг, тамга, тэмдэг
- Төсөл боловсруулсан хуулийн этгээдийн инженер, техникийн ажилтнуудын овог нэр, гарын үсэг, тамга, тэмдэг
- Огноо

4.1.3. Агуулга - Бүлэг, хэсгүүдийн жагсаалт, хуудасны дугаар

4.1.4. Урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэлд дурдагдсан болон боловсруулах явцад ашигласан материалын жагсаалт, тоо баримтын эх сурвалжууд

4.1.5. Хүснэгт, зургийн жагсаалт - Техник, эдийн засгийн үндэслэлд холбогдолтой бүх хүснэгт, график, зургийн жагсаалт

4.1.6. Төсөл хэрэгжүүлэгч, боловсруулагч хуулийн этгээдийн танилцуулга

- Төсөл хэрэгжүүлэгчийн танилцуулга, Улсын бүртгэлийн лавлагаа, холбогдох гэрчилгээ болон тусгай зөвшөөрлийн хуулбар
- Төсөл боловсруулагчийн танилцуулга, Улсын бүртгэлийн лавлагаа, холбогдох гэрчилгээ болон тусгай зөвшөөрлийн хуулбар
- Технологи эзэмшигчийн мэдээлэл

4.1.7. Төслийн танилцуулга

- Төслийн зорилго, зорилт, шийдвэрлэх асуудал, хэрэгцээ шаардлага
- Төрөөс баримталж буй бодлого шийдвэрүүд болон холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд нийцсэн байдал
- Үйлдвэр байгуулах боломжит байршлын харьцуулсан судалгаа
- Төслийн байршил, бүдүүвч зураг, гэрчилгээний хувь
- Хүрээлэн буй орчны шинжилгээ
- Төслийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын хэмжээ, эдийн засгийн хамтын ажиллагаа
- Төсөл хэрэгжүүлэх хугацааг нарийвчлан төлөвлөж, графикаар харуулах
- Үйлдвэрлэлийн хүчин чадал, бүтээгдэхүүний нэр төрөл
- Удирдлага зохион байгуулалт, боловсон хүчиний мэдээлэл
- Үйлдвэрийн ерөнхий бүтэц
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
- Байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх төлөвлөгөө
- Эрчим хүчиний хэмнэлт
- Эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд
- Эрсдэлийн удирдлага

4.1.8. Үйлдвэрлэл

- Түүхий эдийн сонголт түүний нөөц боломж
- Үйлдвэрийн үндсэн ба дайвар бүтээгдэхүүний танилцуулга, дотоодын болон гадаадын үйлдвэрлэлийн ижил төрлийн бүтээгдэхүүнтэй

харьцуулах, зорилтот зах зээлийн судалгаа /бүтээгдэхүүний тооцоолсон үнэ/

- Бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар, дотоодын зах зээл дээр бүтээгдэхүүн борлуулах, экспортын нийлүүлэлтийн магадлал
- Бүтээгдэхүүний хадгалалт
- Түүхий эдийг цогцоор нь боловсруулах, үйлдвэрлэлийн үеийн хог хаягдлыг дахин боловсруулах боломж
- Үйлдвэрийн технологийн процессын харьцуулсан судалгаа /2-оос дээш технологийн харьцуулалт/
- Үйлдвэрлэлийн механижуулалт, автоматжуулалтын түвшний хэрэгцээ, шаардлагыг багтаасан үндсэн технологийн тоног төхөөрөмжийн харьцуулсан судалгаа /нэршил, схем зураг, тайлбарын хамт/
- Тусгай химийн бодис болон нэмэлт түүхий эдийн хэрэглээ, эдийн засгийн тооцоолол, зах зээлийн судалгаа
- Бүтээгдэхүүний туршилтын болон лабораторийн физик-химийн шинж чанарын мэдээлэл
- Үйлдвэрийн лабораторийн үйл ажиллагаа, тоног төхөөрөмжийн судалгаа
- Үйлдвэрлэлийн эдийн засгийн тооцоолол /шаардагдах хөрөнгө оруулалт болон холбогдох зардлуудыг тусгах/
- Товч дүгнэлт

4.1.9. Дэд бүтэц

- Үйлдвэрийн үндсэн болон туслах барилга, байгууламжийн ерөнхий төлөвлөлт /газар зүйн зураглалыг тусгаж өгөх/
- Төсөл хэрэгжих газар нутгийн орон зайн байршлын хэмжээ, хил залгаа сум, орон нутгийн хил хязгаарыг тодорхой тусгах
- Тээврийн оновчтой сонголт, үндсэн шаардлага
- Эрчим хүчний хэрэглээ, шугам сүлжээ, эх үүсвэрийн хангамжийн схемийн талаарх мэдээлэл
- Үйлдвэрлэлд шаардагдах усны хэрэглээ, усан хангамж, нөөцийн судалгаа
- Дэд бүтцэд шаардагдах хөрөнгө оруулалт түүний төлөвлөлт
- Товч дүгнэлт

4.1.10. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, нийгмийн асуудал, аюулгүй ажиллагаа, эрсдэлийн менежмент

- Хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн асуудал, ажлын байрны эрүүл ахуй, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тусгах
- Аюулгүй ажиллагааг баримтлах аюулгүй ажиллагааны дүрмүүд, стандартууд, сургалт зааварчилгааг тусгах
- Ослын үед ажиллах үеийн ажлын схем, холбогдох зураг, дараалал, авч хэрэгжүүлэх арга хэмжээ

- Эрсдэлийн менежмент-мониторинг хийх
- Товч дүгнэлт

4.1.11. Байгаль орчин

- Байгальд орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг багасгах урьдчилсан төлөвлөгөөг боловсруулах
- Байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологийг нэвтрүүлж буй эсэх үйлдвэрээс гарах хорт бодис, хаягдлыг саармагжуулах, хоргүйжүүлэх судалгаа тооцоо
- Байгаль орчныг хамгаалах удирдлагын систем
- Холбогдох дүрэм журмуудыг хэрхэн баримтлах талаар тусгах
- Үйлдвэрийн хаягдлын менежментийг тусгах
- Товч дүгнэлт

4.1.12. Эдийн засаг, санхүүгийн тооцоо

- Эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд
- Борлуулалтын үнэлгээ, орлого
- Үйл ажиллагааны зардал
- Эдийн засгийн үр ашгийн тооцоо
- Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого
- Мөнгөн гүйлгээний төлөв
- Мэдрэмжийн шинжилгээ
- Хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа
- Өнөөгийн үнэ цэнэ, дотоод өгөөжийн түвшин /NPV, IRR, ROI/ хугарлын цэг
- Товч дүгнэлт

4.1.13. Нэгдсэн дүгнэлт

4.1.14. Санал, зөвлөмж

4.1.15. Хавсралт

Тав. Техник, эдийн засгийн үндэслэлийн бүтэц, агуулга

5.1. Хүнд үйлдвэрлэлийн төслийн техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ) дараах бүтэцтэй байна. Үүнд:

5.1.1. Нүүр хуудас - Төслийн нэр, байршил, хүчин чадал, хэрэгжүүлэгч, боловсруулагч хуулийн этгээдийн нэр, огноо

5.1.2. Гарын үсэгний хуудас

- Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн даргын овог нэр, гарын үсэг, тамга, тэмдэг /Танилцсан/

- Төсөл хэрэгжүүлэгч хуулийн этгээдийн удирдлагын овог нэр, гарын үсэг, тамга, тэмдэг /Баталсан/
- Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Боловсруулах үйлдвэрийн салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын овог нэр, гарын үсэг /Хянасан/
- Төслийн зөвлөх инженерийн овог нэр, гарын үсэг, тэмдэг
- Шинжээчийн овог нэр, гарын үсэг /Монгол Улсын зөвлөх болон мэргэшсэн инженер бол тамга, тэмдэг дарна/
- Төсөл боловсруулсан хуулийн этгээдийн удирдлагын овог нэр, гарын үсэг, тамга, тэмдэг
- Төсөл боловсруулсан хуулийн этгээдийн инженер, техникийн ажилтнуудын овог нэр, гарын үсэг, тамга, тэмдэг
- Огноо

5.1.3. Агуулга - Бүлэг, хэсгүүдийн жагсаалт, хуудасны дугаар

5.1.4. Техник, эдийн засгийн үндэслэлд дурдагдсан болон боловсруулах явцад ашигласан материалын жагсаалт, тоо баримтын эх сурвалжууд

5.1.5. Хүснэгт, зургийн жагсаалт - Техник, эдийн засгийн үндэслэлд холбогдолтой бүх хүснэгт, график, зургийн жагсаалт

5.1.6. Төсөл хэрэгжүүлэгч, боловсруулагч хуулийн этгээдийн танилцуулга

- Төсөл хэрэгжүүлэгчийн танилцуулга, Улсын бүртгэлийн лавлагаа, холбогдох гэрчилгээ болон тусгай зөвшөөрлийн хуулбар
- Төсөл боловсруулагчийн танилцуулга, Улсын бүртгэлийн лавлагаа, холбогдох гэрчилгээ болон тусгай зөвшөөрлийн хуулбар
- Техник, технологи эзэмшигчийн мэдээлэл

5.1.7. Төслийн танилцуулга

- Төслийн зорилго, зорилт, шийдвэрлэх асуудал, хэрэгцээ шаардлага
- Төрөөс баримталж буй бодлого шийдвэрүүд болон холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд нийцсэн байдал
- Төслийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын хэмжээ, эдийн засгийн хамтын ажиллагаа
- Үйлдвэр байгуулах боломжит байршлын харьцуулсан судалгаа
- Хүрээлэн буй орчны шинжилгээ
- Төслийн байршил, бүдүүвч зураг, гэрчилгээний хувь
- Үйлдвэрийн ерөнхий бүтэц, барилга байгууламжийн ерөнхий төлөвлөлт, газар зүйн зураглал
- Үйлдвэрлэлийн хүчин чадал, бүтээгдэхүүний нэр төрөл
- Үйлдвэрийн технологийн товч мэдээлэл
- Төсөл хэрэгжүүлэх хугацааг нарийвчлан төлөвлөж, графикаар харуулах
- Удирдлага зохион байгуулалт, боловсон хүчний мэдээлэл
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
- Байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх төлөвлөгөө
- Эрчим хүчний хэмнэлт

- Эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд
- Эрсдэлийн удирдлага

5.1.8. Түүхий эдийн нөөц, хангамж

- Түүхий эдийн ерөнхий мэдээлэл, шинж чанар
- Түүхийн эдийн нөөц, боломж
- Түүхий эдийн сонголт түүний зах зээлийн судалгаа /эрэлт, нийлүүлэлт/
- Химийн бодис болон нэмэлт түүхий эдийн хэрэглээ, зах зээлийн судалгаа /эрэлт, нийлүүлэлт/
- Түүхий эд болон туслах материалын зарцуулалт
- Техникийн шаардлага
- Товч дүгнэлт

5.1.9. Үйлдвэрлэл

- Үйлдвэрийн үндсэн ба дайвар бүтээгдэхүүний танилцуулга, дотоодын болон гадаадын үйлдвэрлэлийн ижил төрлийн бүтээгдэхүүнтэй харьцуулах, зорилтот зах зээлийн судалгаа /бүтээгдэхүүний тооцоолсон үнэ/
- Бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар, дотоодын болон гадаадын зах зээл дээр бүтээгдэхүүн борлуулах, экспортын нийлүүлэлт
- Үйлдвэрийн технологийн процессын судалгаа, сонголт /3-аас дээш технологийг харьцуулан судлах/
- Үйлдвэрлэлийн хүчин чадлын тооцоо, судалгаа /хэрэв үйлдвэрийг цаашид өргөтгөх боломжтой байдлаар төлөвлөсөн бол мөн адил тооцоо, судалгаа хийнэ/
- Үйлдвэрлэлийн механикуулалт, автоматжуулалтын түвшний хэрэгцээ, шаардлагыг багтаасан үндсэн технологийн тоног төхөөрөмжийн харьцуулсан судалгаа /нэршил, схем зураг, тайлбарын хамт/
- Тусгай химийн бодис болон нэмэлт түүхий эдийн хэрэглээ, эдийн засгийн тооцоолол, зах зээлийн судалгаа
- Үйлдвэрийн лабораторийн үйл ажиллагаа, тоног төхөөрөмжийн судалгаа, мэдээлэл
- Бүтээгдэхүүний туршилтын болон лабораторийн физик-химийн шинж чанарын мэдээлэл
- Технологийн туршилтын тайлан, лабораторийн шинжилгээний дүн
- Үйлдвэрлэлийн үеийн хаягдал, байгаль орчны бохирдлын менежментийг тооцоолох
- Ажиллах хүчиний тооцоо, судалгаа /хэрэв тухайн чиглэлийн мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай тохиолдолд боловсон хүчинг сургах, мэргэшүүлэх хөтөлбөр боловсруулах/
- Үйлдвэрлэлийн эдийн засгийн тооцоолол /шаардагдах хөрөнгө оруулалт холбогдох зардлууд, эдийн засгийн үр өгөөж/
- Товч дүгнэлт

5.1.10. Дэд бүтэц

- Үйлдвэрлэлийн болон иргэний барилга байгууламжийн байршил, талбайн гаднах байгууламж, үйлдвэрлэлийн барилгын талбайн ариун цэврийн хамгаалалтын бүсийн хэмжээ
- Дэд бүтцэд шаардагдах хөрөнгө оруулалт түүний төлөвлөлт
- Эрчим хүчний хэрэглээ, шугам сүлжээ, эх үүсвэрийн хангамж, нөөцийн судалгаа
- Үйлдвэрлэлд шаардагдах усны хэрэглээ, эх үүсвэрийн хангамж, нөөцийн судалгаа
- Тээврийн хэрэгслийн оновчтой сонголт, үндсэн шаардлага
- Хууль, дүрэм, журам, стандартууд
- Товч дүгнэлт

5.1.11. Барилга байгууламжийн төлөвлөлт

- Төсөл хэрэгжих газар нутгийн орон зайн байршлын хэмжээ, хил залгаа сум, орон нутгийн хил хязгаар, үйлдвэрийн үндсэн болон туслах барилга байгууламжийн орон зайн байршил, бусад үйл ажиллагаа явуулж буй объектуудын хамт төлөвлөн газар зүйн зураглалаар тодорхой тусгах
- Барилгын талбайн нөхцөл байдлын төлөвлөгөө /үйлдвэрлэлийн болон иргэний барилга байгууламжийн байршил, түүнчлэн талбайн гаднах байгууламж, тээврийн инженерийн холбооны маршрут, үйлдвэрлэлийн барилгын талбайн ариун цэврийн хамгаалалтын бүсийн хэмжээ/
- Үйлдвэрлэлийг өргөжүүлэх боломжтой нутаг дэвсгэрийн нөөц талбайн ерөнхий төлөвлөгөө
- Барилгын ажлыг зохион байгуулах үндсэн үйл ажиллагаа, барилгын ажлын зохион байгуулалтын онцлог, хугацаа
- Аж ахуйн нэгжийн том буюу нарийн төвөгтэй барилга, байгууламжийн үндсэн параметрүүд
- Байгаль орчныг хамгаалах, агаар, хөрс, усны байгууламжийг бохирдуулахаас урьдчилан сэргийлэх, түүнчлэн эвдэрсэн газрын нөмрөгийг нөхөн сэргээх арга хэмжээний тооцоолол
- Үйлдвэрлэлийн барилгын өртгийн тооцоо
- Товч дүгнэлт

5.1.12. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, нийгмийн асуудал, аюулгүй ажиллагаа, эрсдэлийн менежмент

- Хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн асуудал, ажлын байрны эрүүл ахуй, мэргэжлээс шалтгаалах өвчинөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөн зардлыг тусгах
- Аюулгүй ажиллагааг баримтлах аюулгүй ажиллагааны дүрэм, стандартууд, сургалт зааварчилгаатай холбоотой зардлыг төлөвлөх
- Ослын үед ажиллах үеийн ажлын схем, холбогдох зураг, дараалал, авч хэрэгжүүлэх арга хэмжээ

- Эрсдэлийн менежмент-мониторинг хийх
- Товч дүгнэлт

5.1.13. Байгаль орчин

- Байгальд орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг багасгах төлөвлөгөө /Байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологийг нэвтрүүлж буй эсэх/
- Байгаль орчныг хамгаалах удирдлагын систем
- Холбогдох дүрэм, журмуудыг хэрхэн баримтлах талаар тусгах
- Усмал болон хортой бодисын хадгалалт хамгаалалт, саармагжуулалт
- Хөрсөнд хортой бодис нэвчихээс сэргийлэх ажлын төлөвлөгөө
- Байгаль орчныг хамгаалах зардлын тооцоолол
- Товч дүгнэлт

5.1.14. Эдийн засаг, санхүүгийн тооцоо

- Эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд
- Хөрөнгө оруулалт
- Санхүүжилтийн эх үүсвэр, хуваарь
- Борлуулалтын үнэлгээ, орлого
- Үйл ажиллагааны зардал
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардал
- Бүтээгдэхүүний өртгийн тооцоо
- Татвар, төлбөр
- Үндсэн хөрөнгийн элгэдэл
- Хаалт нөхөн сэргээлтийн зардал
- Орон нутгийн хамтарч ажиллах зардал
- Эдийн засгийн үнэлгээ, үр ашгийн тооцоо
- Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого
- Мөнгөн гүйлгээний төлөв
- Мэдрэмжийн шинжилгээ
- Хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа
- Өнөөгийн үнэ цэнэ, дотоод өгөөжийн түвшин /NPV, IRR, ROI/ хугарлын цэг
- Товч дүгнэлт

5.1.15. Ерөнхий дүгнэлт

5.1.16. Санал, зөвлөмж

5.1.17. Хавсралт

**Зургаа. Нарийвчилсан техник, эдийн засгийн
үндэслэлийн бүтэц, агуулга**

6.1. Хүнд үйлдвэрийн төслийн нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэл (НТЭЗҮ) дараах бүтэцтэй байна. Үүнд:

6.1.1. Нүүр хуудас - Төслийн нэр, байршил, хүчин чадал, хэрэгжүүлэгч, боловсруулагч хуулийн этгээдийн нэр, огноо

6.1.2. Гарын үсэгний хуудас

- Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн даргын овог нэр, гарын үсэг, тамга, тэмдэг /Танилцсан/
- Төсөл хэрэгжүүлэгч хуулийн этгээдийн удирдлагын овог нэр, гарын үсэг, тамга, тэмдэг /Баталсан/
- Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Боловсруулах үйлдвэрийн салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын овог нэр, гарын үсэг /Хянасан/
- Төслийн зөвлөх инженерийн овог нэр, гарын үсэг, тэмдэг
- Шинжээчийн овог нэр, гарын үсэг /Монгол Улсын зөвлөх болон мэргэшсэн инженер бол тамга, тэмдэг дарна/
- Төсөл боловсруулсан хуулийн этгээдийн удирдлагын овог нэр, гарын үсэг, тамга, тэмдэг
- Төсөл боловсруулсан хуулийн этгээдийн инженер, техникийн ажилтнуудын овог нэр, гарын үсэг, тамга, тэмдэг
- Огноо

6.1.3. Агуулга - Бүлэг, хэсгүүдийн жагсаалт, хуудасны дугаар

6.1.4. Техник, эдийн засгийн үндэслэлд дурдагдсан болон боловсруулах явцад ашигласан материалын жагсаалт, тоо баримтын эх сурвалжууд

6.1.5. Хүснэгт, зургийн жагсаалт - Техник, эдийн засгийн үндэслэлд холбогдолтой бүх хүснэгт, график, зургийн жагсаалт

6.1.6. Төсөл хэрэгжүүлэгч, боловсруулагч хуулийн этгээдийн танилцуулга

- Төсөл хэрэгжүүлэгчийн танилцуулга, Улсын бүртгэлийн лавлагаа, холбогдох гэрчилгээ болон тусгай зөвшөөрлийн хуулбар
- Төсөл боловсруулагчийн танилцуулга, Улсын бүртгэлийн лавлагаа, холбогдох гэрчилгээ болон тусгай зөвшөөрлийн хуулбар
- Техник, технологи эзэмшигчийн мэдээлэл

6.1.7. Төслийн танилцуулга

- Нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэлийн зорилго, зорилт, шийдвэрлэх асуудал, хэрэгцээ шаардлага
- Төрөөс баримталж буй бодлого шийдвэрүүд болон холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд нийцсэн байдал
- Одоо байгаа үйлдвэрлэлийн техникийн байдал, түүний үйл ажиллагааны дүн шинжилгээ, үнэлгээ, сүүлийн хоёр, гурван жилийн техник, эдийн засгийн гүйцэтгэлийн үзүүлэлтүүд (байгууламжийг сэргээн босгох, шинэчлэх явцад гарсан өөрчлөлтүүд)
- Хөрөнгө оруулалтын хэмжээ
- Үйлдвэрлэлийн хүчин чадлын үндэслэл
- Хувилбар боловсруулах, боломжит технологийн схемүүдийг харьцуулах үндсэн дээр батлагдсан үйлдвэрлэлийн технологийн үндэслэл
- Үйлдвэрлэлийн бүтэц, бүрэлдэхүүн, аж ахуйн нэгжийн удирдлага

- Төсөл хэрэгжүүлэх хугацааг нарийвчлан төлөвлөж, графикаар харуулах
- Хүрээлэн буй орчны шинжилгээ
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
- Байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө
- Эрчим хүчний хэмнэлт
- Эдийн засгийн үндсэн үзүүлэлт
- Эрсдэлийн удирдлага

6.1.8. Түүхий эдийн нөөц, хангамж

- Түүхий эдийн өрөнхий мэдээлэл, шинж чанар
- Түүхий эдийн сонголт, нөөц боломж, боловсруулалтын технологи, хадгалалт, тээвэрлэлт зэргийн судалгаа, түүхий эд, материал, хагас боловсруулсан бүтээгдэхүүний хэрэгцээ, бэлтгэлд тавигдах шаардлага
- Түүхий эдийн сонголт түүний зах зээлийн судалгаа /эрэлт, нийлүүлэлт/
- Химийн бодис болон нэмэлт түүхий эдийн хэрэглээ, зах зээлийн судалгаа /эрэлт, нийлүүлэлт/
- Түүхий эд болон туслах материалын зарцуулалт
- Техникийн шаардлага
- Түүхий эдийн эдийн засгийн үндэслэл
- Товч дүгнэлт

6.1.9. Үйлдвэрлэл

- Үйлдвэрийн хүчин чадлын тооцоо, судалгаа /хэрэв үйлдвэрийг цаашид өргөтгөх боломжтой байдлаар төлөвлөсөн бол мөн адил тооцоо, судалгаа хийнэ/
- Нэмэлт түүхий эд болон тусгай химийн бодисын хэрэглээ, эдийн засгийн тооцоолол, зах зээлийн судалгаа
- Технологийн сонголтын талаарх мэдээлэл /олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эсэх, үйлдвэрлэлд нэвтэрсэн байдал/
- Үйлдвэрт ашиглагдах технологи бүрийн технологийн схем зургийг нарийвчлан нэршил, тайлбарын хамт тусгах
- Үйлдвэрт ашиглагдах технологийн тоног төхөөрөмжийг тодорхой жагсаасан байх бөгөөд тоног төхөөрөмж бүрийн зах зээлийн үнэ, нэршлийг тайлбарын хамт нарийвчлан тусгах
- Үйлдвэрийн үндсэн ба дайвар бүтээгдэхүүний танилцуулга, зорилтот зах зээлийн судалгаа, хадгалалт, тээвэрлэлт, борлуулах сүлжээг тодорхой тусгах
- Үйлдвэрлэх бүтээгдэхүүний туршилтын болон физик, химийн шинж чанарын мэдээлэл
- Үйлдвэрийн лабораторийн үйл ажиллагаа, тоног төхөөрөмжийг нарийвчлан тусгах
- Үйлдвэрлэлийн үед үүсэх хаягдлын судалгаа

- Ажиллах хүчний тооцоо, судалгаа /хэрэв тухайн чиглэлийн мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай тохиолдолд боловсон хүчинг сургах, мэргэшүүлэх хөтөлбөр боловсруулах/
- Хөрөнгө оруулалтын тооцоо, эдийн засгийн үр өгөөжийн талаарх тооцоолол
- Үйлдвэрлэлийн эдийн засгийн тооцоолол, холбогдох зардлын тооцоолол
- Товч дүгнэлт

6.1.10. Дэд бүтэц

- Дэд бүтцийн судалгаа /түүхий эдийн болон үйлдвэрлэх бүтээгдэхүүний тээвэрлэлтийн схем, тооцоо судалгаа/
- Холбогдох хууль, дүрэм, журам, стандартууд
- Эрчим хүчний нөөц, хэрэглээ, шугам сүлжээ, эх үүсвэрийн хангамжийн схем
- Үйлдвэрлэлд шаардагдах усны хэрэглээ, эх үүсвэрийн усан хангамж, нөөцийн судалгаа
- Тээврийн хэрэгслийн оновчтой сонголт, сонголтыг харгалзан тээврийг хөгжүүлэх үндсэн шаардлага
- Хууль, дүрэм, журам, стандартууд
- Дэд бүтцэд шаардагдах хөрөнгө оруулалт түүний төлөвлөлт
- Товч дүгнэлт

6.1.11. Барилга байгууламжийн төлөвлөлт

- Төсөл хэрэгжих газар нутгийн орон зайн байршлын хэмжээ, хил залгаа сум, орон нутгийн хил хязгаар, үйлдвэрийн үндсэн болон туслах барилга байгууламжийн орон зайн байршил, бусад үйл ажиллагаа явуулж буй объектуудын хамт төлөвлөн газар зүйн зураглалаар тодорхой тусгах
- Барилгын талбайн нөхцөл байдлын төлөвлөгөө /үйлдвэрлэлийн болон иргэний барилга байгууламжийн байршил, түүнчлэн талбайн гаднах байгууламж, тээврийн инженерийн холбооны маршрут, үйлдвэрлэлийн барилгын талбайн ариун цэврийн хамгаалалтын бүсийн хэмжээ/
- Үйлдвэрлэлийг өргөжүүлэх боломжтой нутаг дэвсгэрийн нөөц талбайн ерөнхий төлөвлөгөө
- Барилгын ажлыг зохион байгуулах үндсэн үйл ажиллагаа, барилгын ажлын зохион байгуулалтын онцлог, хугацаа
- Аж ахуйн нэгжийн том буюу нарийн төвөгтэй барилга, байгууламжийн үндсэн параметрүүд
- Байгаль орчныг хамгаалах, агаар, хөрс, усны байгууламжийг бохирдуулахаас урьдчилан сэргийлэх, түүнчлэн эвдэрсэн газрын нэмрэгийг нөхөн сэргээх арга хэмжээний тооцоолол
- Үйлдвэрлэлийн барилгын өртгийн тооцоо
- Товч дүгнэлт

6.1.12. Хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн асуудал, аюулгүй ажиллагаа, эрсдлийн менежмент

- Хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн асуудал, ажлын байрны эрүүл ахуй, мэргэжлээс шалтгаалах өвчинөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөн зардлыг тусгах
- Аюулгүй ажиллагааг баримтлах аюулгүй ажиллагааны дүрэм, стандартууд, сургалт зааварчилгаатай холбоотой зардлыг төлөвлөх
- Ослын үед ажиллах үеийн ажлын схем, дараалал, холбогдох зураг, авч хэрэгжүүлэх арга хэмжээ
- Эрсдлийн менежмент
- Товч дүгнэлт

6.1.13. Байгаль орчин

- Байгаль орчныг хамгаалах удирдлагын систем
- Холбогдох хууль, дүрэм, журам, стандартууд
- Байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг багасгах төлөвлөгөө
- Байгаль орчны бохирдлын менежментийг тооцоолох
- Уусмал болон хортой бодисын хадгалалт хамгаалалт, саармагжуулалт
- Хөрсөнд хортой бодис нэвчихээс сэргийлэх ажлын төлөвлөгөө
- Онцгой байдалд ажиллах арга хэмжээний схем
- Байгаль орчныг хамгаалах зардлын тооцоо /байгаль орчныг бохирдуулсан тохиолдолд нөхөн сэргээх төлөвлөгөөг, гарах зардлын хамт тооцоолж тусгах/
- Товч дүгнэлт

6.1.14. Эдийн засаг, санхүүгийн тооцоо

- Эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд
- Хөрөнгө оруулалт
- Санхүүжилтийн эх үүсвэр, хуваарь
- Борлуулалтын үнэлгээ, орлого
- Үйл ажиллагааны зардал
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардал
- Бүтээгдэхүүний өртгийн тооцоо
- Татвар төлбөр
- Үндсэн хөрөнгийн элгэдэл
- Хаалт нөхөн сэргээлтийн зардал
- Орон нутгийн хамтарч ажиллах зардал
- Эдийн засгийн үнэлгээ, үр ашгийн тооцоо
- Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого
- Мөнгөн гүйлгээний төлөв
- Мэдрэмжийн шинжилгээ
- Өнөөгийн үнэ цэнэ, дотоод өгөөжийн түвшин /NPV, IRR, ROI/ хугарлын цэгийн олон улсын стандартын дагуу CAPEX, OPEX тооцооллоор тооцох
- Хөрөнгө оруулалт нөхөн хугацааг тодорхойлох
- Товч дүгнэлт

6.1.15. Ерөнхий дүгнэлт

6.1.16. Санал, зөвлөмж

6.1.17. Хавсралт

**Долоо. Техник, эдийн засгийн үндэслэлд тодотгол
хийх болон шинэчлэн боловсруулах**

- 7.1. Үйлдвэрийн төсөлд хүчин чадал, техник, технологийн өөрчлөлт орсон, үйлдвэрлэх бүтээгдэхүүний нэр төрөл өөрчлөгдсөн болон техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулснаас хойш З ба түүнээс дээш жил үйл ажиллагаа явуулаагүй мөн үйлдвэрийн тусгай зөвшөөрөл эзэмшигч өөрчлөгдсөн тохиолдолд төсөл хэрэгжүүлэгч хуулийн этгээд техник, эдийн засгийн үндэслэлийг тодотгох, шинэчлэх буюу шинээр боловсруулах үүргийг хүлээнэ.

Найм. Бусад

- 8.1. Техник, эдийн засгийн үндэслэлд шинжээч томилуулах, хэлэлцүүлж батлуулахтай холбоотой өргөдөл, хүсэлтийг Эрдэс баялаг мэргэжлийн зөвлөлийн Боловсруулах үйлдвэрийн салбар зөвлөлд цахим систем <https://mpc.mmhi.gov.mn/>-ээр дамжуулан ирүүлнэ.
- 8.2. Төсөл хэрэгжүүлэгч нь техник, эдийн засгийн үндэслэлд мэргэжлийн шинжээчдээр дүгнэлт гаргуулан Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Боловсруулах үйлдвэрийн салбар зөвлөлийн өргөтгөсөн болон салбар хуралдаанаар хэлэлцүүлж батлуулна.
- 8.3. Батлагсан техник, эдийн засгийн үндэслэлийг хэвлэмэл болон түүнийг хуулсан диск /CD/ хэлбэрээр тус бүр З хувь үйлдсэн байх бөгөөд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Хүнд үйлдвэрийн бодлогын газар, Геологийн төв архив, төсөл хэрэгжүүлэгчид тус тус нэг хувийг хадгална.
- 8.4. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Хүнд үйлдвэрийн бодлогын газар нь хүлээн авсан ТЭЗҮ-ийн хэвлэмэл болон түүний хуулсан дискийг үйлдвэрийн технологийн үйл ажиллагаа, үйлдвэрийн барилга, тоног төхөөрөмжийн суурилуулалт, зураг төсөл, техник, эдийн засгийн үндэслэлд тодорхойлсны дагуу хийгдсэн эсэхэд хяналт тавих зорилгоор ашиглана.

---00---